



ажлын магистр

О.ПҮРЭВСҮРЭН

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч, нийгмийн

ХОРИХ АНГИ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс Ардын түр засгийн газрын шийдвэрээр “Гяндан салаа” нэртэйгээр байгуулагдсан байдаг. Тэр цаг үеэс өнөөдрийг хүртэлх хугацаанд хорих ял шийтгэгдсэн хоригдогсдын хорих орчин нөхцөл, хөдөлмөр эрхлэлт, төрөлжүүлсэн сургалттай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн түүхтэй. Хорих байгууллагад ажиллаж байсан үе үеийн нийгмийн ажилтан нар нь нийгмийн хөгжлийн тогтолцооны явцад өөр өөрийн үндсэн чиглэл, үйл ажиллагаа нь тодорхой нэр томъёог ашиглаж ирсэн байна. Тухайлвал 1997 он хүртэлх хугацаанд “Улс төр, хүмүүжлийн хэлтэс” нэр, зохион байгуулалттайгаар хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадуудад “Сурган хүмүүжүүлэгч” ажиллаж тухайн үед хоригдогч, ялтны хөдөлмөр зохион байгуулалтанд анхаарч улсын чанартай ажилд татан оролцуулж ирсэн байна.


1997-2003 оноос эрх зүйн харилцааг нь өөрчилж, тэдний ажиллах орчныг чөлөөт амьдралд аль болохоор ойртуулан, иргэншүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зорилго, чиглэлтэй “Ахуй дэглэмийн байцаагч” нар ажиллаж байсан ба 2003 оноос эхлэн хорих байгууллагад нийгмийн ажил гэсэн

нэр томъёо орж ирэн анги албанд нийгмийн ажилтан ажиллаж хоригдогсдыг нийгэмшүүлэх, тулгарсан бэрхшээлийг даван туулахад нь туслах чиг үүрэг, зорилго дэвшүүлэн ажиллаж өнөөг хүртэл ажилласан.

Энэхүү илтгэлийг бичих болсон үндсэн зорилго чиглэл маань одоогийн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажиллаж байгаа нийгмийн ажилтан нарт тулгамдаж буй асуудлыг анкетийн болон бичиг баримтанд дүн шинжилгээ хийх аргаар тодорхойлон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар өөрийн санал, зөвлөмжийг гаргахыг зорьлоо.


Өнөөдөр хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий ШШГЕГ-ын харьяа Тогтоол гүйцэтгэх газрын Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс ажиллаж доорхи чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хорих анги, албадын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах, шалган зааварчлах ажлыг зохион байгуулах
- Нийгэмшүүлэх ажлын хүрээнд гарсан хууль тогтоомж тушаал, шийдвэрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах,
- Хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх, ур чадварийг нь дээшлүүлэх, чадавхижуулах ажлыг удирдан зохион байгуулах,



- Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах, олон нийтэд сурталчлах,
- Хорих байгууллагын эмнэлэгийн ажилтныг мэргэшүүлэх, ур чадварийг дээшлүүлэх, хоригдогчдыг эрүүлжүүлэхэд хяналт, дүн шинжилгээ хийх.
- Хоригдогсдыг нийгэмшүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэрэг ажлыг зохион байгуулж байна.

Өнөөгийн байдлаар хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд нийт 75 нийгмийн ажилтан ажиллаж байгаа эдгээрийг мэргэжлээр авч үзвэл 53 нь буюу 77 хувь эрх зүйч мэргэжилтэй, харин нийгмийн ажлын үндсэн мэргэжилтэй, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх




ажилтан 9 буюу 11 хувь нь эзэлж байгаа нь цаашид хорих байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтныг мэргэжлийн боловсон хүчнийг бүрдүүлэх, одоогийн ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудыг

мэргэшүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Анкетийн аргаар авсан судалгаанд нийт хорих анги, шийдвэр гүйцэтгэх албан ажиллаж байгаа 52 нийгмийн ажилтан хамрагдсан.

Тус судалгаанаас 2 асуулгын онцлон авч дүн шинжилгээ хийхэд "Нийгмийн ажилтны үйл ажиллагаанд сөрөг байдлаар нөлөөлж байгаа бэрхшээлтэй асуудал юу байна вэ?" гэсэн асуултанд хариулт өгсөн байдлаас авч үзвэл: Тухайн бэрхшээлтэй гэж үзсэн асуудлын 70 гаруй хувь хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны дотоод нөөц боломжын хүрээнд шийдвэрлэх бүрэн боломжтой байгааг асуудлууд байгааг харуулж байна.



Хорих анги анги, шийдвэр гүйцэтгэх албан ажиллаж байгаа нэг нийгмийн ажилтанд ногдох хоригдогчын тоо маш өндөр байгаа гэсэн хариултыг 9 нийгмийн ажилтан буюу 17.8 хувь үзсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 205/94 дугаар хамтарсан тушаалын нэг дүгээр хавсралтын № 1-т "ШШГЕГ-ын албан хаагчдын ажлын ачаалалын жишиг норматив"-ын төвлөрсөн хорих ангид 200-250 хоригдолд нэг нийгмийн ажилтан ажиллахаар заасан байна, тэгвэл олон улсын жишиг нормативаас үзэхэд Герман улсад нэг нийгмийн ажилтанд 70-80, Швейцарьт 60-80, Оросын Холбооны Улсад нэг нийгмийн ажилтанд дэглэмээс



шалтгаалан хоригдогчын тоо 60-70 байхаар тогтоосон байна.

Иймээс хорих анги шийдвэр гүйцэтгэх албанд ажиллаж байгаа нийгмийн ажилтны ажлын ачаалал өндөр байгаа төдийгүй, ажлын үр дүнгийн үзүүлэлтэнд шууд нөлөөлж байна гэж үзэж байна.


Нийгмийн ажилтан та ямар төрлийн сургалтанд хамрагдах хүсэлтэй вэ? гэсэн асуултанд доорхи хариултыг өгсөн байна.

Дээрх хариултаас үзэхэд өмнө нийгмийн ажилтны дунд анх 2006 онд ШУТИС-иас мэргэшүүлэх сургалт, үүний дараа 2011 онд 9 өдрийн сургалт, 2012 онд 2 өдрийн сургалтыг тус тус зохион байгуулж байсан ба дараагийн сургалтыг ажлын байран дээр болон нийгмийн ажлын чиглэлээр практик дадлагын сургалтанд хамруулах нь зохих үр дүнтэй гэж үзсэн байна.

Цаашид хорих байгууллагын нийгмийн ажлын чиглэлээр баримтлах бодлого чиглэл, хийх ажлын талаар бичнэ үү? гэсэн нээлттэй асуултанд доорхи саналуудыг гаргасан байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай МУ-ын хуульд ял эдлэх дэглэм буулгахад гэм хорын төлбөрийн хэмжээг зааж өгөөгүй байгааг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган оруулах.
- Хорих ангийн нийгмийн ажилтныг бүсчилсэн хэлбэрээр баг болгож хорих ангиудаар тодорхой хугацаанд, давтамжтайгаар хамтарсан судалгааны болон туршлага солилцох, нийгмийн ажлын практикаас суралцах ажлыг тасралгүйгээр зохион байгуулах
- Цагдан хоригдогсод нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор цагдан хоригдогсод зориулсан нийгмийн

Нийгмийн ажилтны үйл ажиллагаанд сөрөг байдалаар нөлөөлж байгаа бэрхшээлтэй асуудал





ажилтны зааврыг боловсруулан, журмын биелэлтийг хангаж ажиллуулах.

- Хорих байгууллагын нийгэмшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, ялтан, хоригдогчдод нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад харуул хамгаалалтын албанаас хараат биш байдлаар зохион байгуулахад эрх зүйг орчинг бүрдүүлэх.
- Хорих байгууллагын нийгмийн ажлын талаарх мэдлэг, мэдээлэл, сургалт зохион байгуулах ажлыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын дунд зохион байгуулахаар төлөвлөн хичээл, сургалтын хөтөлбөрт оруулах.
- Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнуудын дунд спорт, урлаг, ур чадварын нөхөрсөг тэмцээнүүдийг гэрээт сургууль болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор уламжлал болгон зохион байгуулж байх.
- Хорих байгууллагын нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн ном, гарын авлага бэлтгэх ажлыг сайжруулах.
- Хоригдогсдод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг төрөл, дэглэм, ангийн байршил, хөдөлмөр эрхлэлтийг харгалзан үзэж ялгамжтай байдлаар зохион байгуулах.
- Хоригдогсдыг нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хамтарсан төсөлт хөтөлбөр хэрэгжүүлэхэд удирдах ажилтны зүгээс онцгойлон анхаарч ажиллах зэрэг саналыг тус тус гаргасан байна.

Түүнчлэн дээрхи арга хэмжээнүүдтэй уялдуулан нийгмийн ажлын үйлчилгээг хүртээмжтэй, үр дүнтэй болгох зорилгоор дараахи санал,

зөвлөмжийг судлаачын дүгээс дэвшүүлж байна. Үүнд:

1. Нийгмийн ажлын мэргэжлийн албыг бий болгон нэг нийгмийн ажилтанд оногдох хоригдогсдын тоог олон улсын жишиг нормативт хүргэх;
2. Хорих анги болон баривчлах, цагдан хорих байранд хоригдогсдыг зүйл анги, хэргийн төрөл, хувийн онцлог, хэрэгцээнд нь тулгуурлан нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх;
3. Хорих ангийн дарга, дэд дарга, даргын зөвлөлийн оролцоотойгоор хоригдогсдын дунд ярилцлага, уулзалтыг тогтмол зохион байгуулж, нийгмийн ажлын үйлчилгээнд зориулсан төсвийг тусгайлан гаргах;
4. Хоригдогсдыг нийгэмшүүлэх ажилд харуул хамгаалалтын ажилтныг татан оролцуулах, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;
5. Судлаач, эрдэмтэн багш, нийгмийн ажилтны арга зүйн баг бүрдүүлэн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажлын байран дээрх сургалт, арга зүйн дадлага ажлыг тасралтгүйгээр зохион байгуулах зэрэг санал дүгнэлтийг оруулж байна.

Хоригдогсдыг нийгэмшүүлэх ажил зөвхөн ганц нийгмийн ажилтны үйл ажиллагаагаар хэмжих биш баг, хамт олны дэмжлэг тусалцаатайгаар явагддаг учир тус анги, албаны ажилтан, албан хаагчдыг татан оролцуулах зайлшгүй шаардлагатай байна.

Аливаа нэг ажлын эцсийн үр дүн нь хорих анги, албад нэгжийн хамтын ажиллагаа, тухайн ажилтны мэргэжлийн ур чадвар, зорилгоо зөв тодорхойлсон эсэх, төлөвлөлтийг хэрхэн үр дүнтэй хийсэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг цогц байдлаар амжилттай хэрэгжүүлэхээс шууд хамааралтай учир дээрхи санал зөвлөмж нь хоригдогсдыг нийгэмшүүлэх ажилд бага ч болов дөхөм болох байх гэдэгт итгэлтэй байна.